



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

"Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт" нийцлийн аудит
ҮАГ-НАГ/2017/01-НА-ХөААГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн нийцлийн аудитын тайлан

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд дотоод хяналт тавьж ажиллаагүйгээс зөрчил дутагдал өмнөх онуудаас нэмэгдсэн байна.

**Хөвсгөл аймаг
2017 оны 4 дүгээр сар**



АГУУЛГА		№
Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	3
ХөААГ-ын Нийцлийн аудитын баг	Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй	4
	Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт	5
Тэргүүлэх аудитор	Үндсэн мэдээлэл	5
Г.Оюунгэрэл		
Утас: 99909224	Бүлэг 1. ОНХС-аас аймагт ирэх орлогын шилжүүлгийг хасаж тодотгол хийж байгаагаас өр үүсэх, төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэж чадахгүй болох эрсдэл бий болж байна.	6
Аудитын менежер	1.1. ОНХС-аас ирэх орлогын шилжүүлгийг 2016 онд 1040,4 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна.	6
Г.Эрдэнэчимэг	1.2. ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.	8
Утас: 99016320	1.3. Сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна.	9
Ахлах аудитор	1.4. ОНХС-аас санхүүжих орлогын шилжүүлэг хугацаандаа ирээгүйгээс сумдад олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.	10
Б.Тэгшдэлгэр		
Утас: 99089114	Бүлэг 2. Иргэдийн саналаар дэмжигдээгүй, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж байна.	12
Шинжээч	2.1 Сумдад тухайн жилд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг бэлтгэх ажил хангалтгүй байна.	20
Э.Бат-эрдэнэ	2.2 Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлуудыг жагсаалтад оруулж сумын ИТХ-аар батлуулж хэрэгжүүлсэн байна.	
Утас: 99900662	2.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангаагүй нийт 335,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.	
2016 оны IV сар	2.4 Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043, 70384044 дугаарын утсаар харилцана уу.	2.5 ОНХС-ийн 19,6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	
	2.6 Ихэнх сумууд нь төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үр дүнтэй тавихгүй байна.	
	2.7 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлд тусган ажиллаж байна.	
	Бүлэг 3. Шат шатны ИТХ-аас ОНХС-д тавих хяналтыг үр дүнтэй хийж чадахгүй байна.	21
ХАЯГ:	3.1 Сумдын 2016 оны ОНХС-ийн хэрэгжилтийн 80%-д хяналт хийгээгүй байна.	
	3.2 Ажлын хэсэг байгуулж, сумдын тухайн жилийн ОНХС-ийн тайланд дүн шинжилгээ хийж хэвшээгүй байна.	21

Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар Цахим хаяг: audit.mn	3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн байна.	22
	3.4 Төсвийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан ОНХС-ийн “Заавар”-ыг өөрчлөх шаардлагатай байна.	24
	3.5 Өмнөх оны аудитаар өгсөн акт хэрэгжээгүй, албан шаардлагын хэрэгжилт 50%, зөвлөмж хэрэгжилт 71,9% байна.	25
	4. ДҮГНЭЛТ 5. ЗӨВЛӨМЖ	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлбар
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан ТБОНӨХБАҮХАТ
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын их хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, ЕА-ын 2017 оны А/12 дугаар тушаал, ҮАГ-ын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмжийг боловсруулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг батлагдсан хуваарийн дагуу ОНХНС-аас Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн санд 2016 онд хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон холбогдох бусад баримтад тулгуурлан гүйцэтгэв.

Аудитад аймгийн ОНХС болон 23 сум, 1 тосгоны ОНХС, аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын СТСХ, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн өмчийн газар, багийн засаг дарга, Иргэдийн нийтийн хурлыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын горимын дагуу нотлох баримт цуглуулан ажиллав. Аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан тайлан бичиж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж байна.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- МУ-ын 2016 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- Иргэний хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаал
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал
- Бусад холбогдох хууль, тогтоомж

БҮЛЭГ- 1. ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэгт хасаж тодотгол хийж байгаагаас өр үүсэх, төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэж чадахгүй болох эрсдэл бий болж байна.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Монгол улсын 2016 оны төсвийн тодотголоор орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 1040.4 сая төгрөгөөр бууруулан 3395.6 сая төгрөгөөр баталсан байна. Аймгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 2015 оны орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн дутууг нөхөж 181.0 сая төгрөгийг нэмж баталсан байна.

2016 оны ОНХС-ийн гүйцэтгэл аймагт 1591,8 сая төгрөг, сумдад 2512,5 сая төгрөг, нийт 4104,3 сая төгрөг байна.

1.1 ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 2016 онд 1040,4 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Журам”-ын 6.1.1-д заасан ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1.3-т заасны дагуу 2016 онд ОНХНС-аас Хөвсгөл аймагт 4435,9 сая төгрөгийг Сангийн яам тооцож төлөвлөсөн байна.

2016 оны 9 дүгээр сард 2016 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 1040,0 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд:

№	Эх үүсвэр	Оны эхэнд	Тодотгол	Оны дундуур ОНХС-д хасах тодотгол хийсэнтэй
1	ОНХНС	4435,9	3395,6	

холбогдуулан 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний санхүүжих эх үүсвэр дутагдан ИТХ-аар баталсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Тухайлбал: Аймаг, сумдад нийт 689,1 сая төгрөгийн өр үүссэн байна.

1.2 ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

2016 оны ОНХС-г санхүүжүүлэх эх үүсвэрийг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1-д заасан аргачлалыг баримтлан тооцож төлөвлөсөн байна. Үүнд:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	ОНХНС	Үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсгийг хассан дүн	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр	бусад эх үүсвэр
ИТХ-ын ТОГТООЛ 2015.12.03	0	4435,9	0	79,8	0
ИТХ-ын 2016.04.06-ны өдрийн тогтоолоор	+20,6		0	0	+181,0
ИТХ-ын 2016.09.23 өдрийн тогтоолоор		-1040,0	0		
Нийт эх үүсвэрийн дүн гэх	20,6	3395,9	0	79,8	181,0

Хүснэгтээс харахад аймгийн ОНХС-д орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 181,0 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон орлогоос 79,8 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

1.3 Сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна.

2016 онд төлөвлөсөн хэмжээнд ОНХНС-аас 3395,6 сая төгрөгийн санхүүжилт авч аймаг, сумдад ОНХС-ын эх үүсвэрийг дараах байдлаар бүрдүүлсэн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	ОНХНС	Үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсгийг хассан дүн	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр	Дотоод гадаадын хандив тусламж болон бусад	Нийт эх үүсвэр
Аймаг	20,6	1310,4		79,8	181,0	1591,8
Сумууд	112,7	2084,9	281,2	33,7	0	2512,5
Нийт	133,3	3395,3	281,2	113,5	181,0	4104,3

1.4 ОНХНС-аас санхүүжих орлогын шилжүүлэг хугацаандаа ирэхгүй байгаагаас сумдад олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгохгүй байна.

Аймаг, сумдад олгох ОНХС-ийн хөрөнгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал болон Төсвийн тухай хуулийн **/хуучнаар/** 59 дүгээр зүйлийн 59.2¹-т заасны дагуу ОНХС-аас олгох шилжүүлгийг сумдын ОНХС-д хуваарилж баталсан байна.

ОНХС-аас санхүүжих орлогын шилжүүлэг хугацаандаа ирэхгүй байгаагаас аймгийн СТСХ-ээс сумдад олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгож чадаагүй байна. **Тухайлбал:** 1,8,10,11 саруудад сумдад олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийг тухайн сард нь хуваарийн дагуу олгоогүй байна.

БҮЛЭГ-2: Иргэдийн саналаар дэмжигдээгүй, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж байна.

Үндсэн мэдээлэл

2016 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт 306 төсөл арга хэмжээний 4928,9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас 284 төсөл арга хэмжээг 4447,0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна. Батлагдсан төсөл арга хэмжээнээс дутуу хэрэгжсэн 19, огт хэрэгжээгүй 31 төсөл, арга хэмжээ байна. /Судалгаа №2/ Судалгаанаас харахад тухайн онд батлагдсан эх үүсвэрээс илүү төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байгаа нь ОНХС-д хийсэн тодотголтой холбоотой байна.



Графикаас харахад нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын 84% нь бүрэн хэрэгжсэн, 6% нь дутуу хэрэгжсэн, 10% нь ОНХС-ийн эх үүсвэрт хасах тодотгол хийсэнтэй холбоотой огт хэрэгжээгүй байна.

2.1 Сумдад тухайн жилд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг бэлтгэх ажил хангалтгүй байна.

Сумдын тухайд: Нийцлийн аудитаар ажилласан сумдын баримт материалаас харахад Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан зааврын 5.7-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжих төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн тухайд: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжих төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлын урьдчилсан жагсаалт бэлтгэх ажлыг аймгийн ХБХ-ийн дарга Х.Ган-Очир ахлан зохион байгуулсан байна. Ажлын хэсгийн хурлыг 2015.04.21-нд сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарыг оролцуулан 250 хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлсэн байна. Хэлэлцүүлгийн үр дүнд

¹Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн сангаас энэ хуулийн 59.1.1-59.1.5-д заасан орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна

2016 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 7 ТАХ-г хэрэгжүүлэх урьдчилсан жагсаалт бэлтгэж, иргэдээс санал авахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Мөрөн сумын 6,7,8,2 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар
2. Тариалан, Шинэ-Идэр, Их-уул, Хатгал, Түнэл, Эрдэнэбулган сумдад хүүхдийн зуны сувилал шинээр барих
3. Нэгдсэн эмнэлэгийн хүүхдийн тасгийн тоног төхөөрөмж шинэчлэх
4. Бүрэнтогтох, Шинэ-идэр, Мөрөн сумын 2,4,5 дугаар цэцэрлэг, Алаг-эрдэнэ, Цагаан-уул, Чандмань-өндөр, Рашаант сумын цэцэрлэг, Их-уул, Эрдэнэбулган сумын дотуур байранд ус ариун цэврийн байгууламж шинээр барих
5. Бүх сумдын сургууль, цэцэрлэгийн гаднах хогийн цэгийг нэгдсэн стандарттай болгох
6. Баянзүрх, Шинэ-идэр, Их-уул сумдын эмнэлгийн хог хаягдлыг халдваргүйжүүлэх /автокалов./
7. Их-уул сумын спорт заалны дуусгалт

Дээрх ТАХ-ний жагсаалтыг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Журам”-ын 6.3 дахь заалттай нийцэж байгаа эсэхийг үнэлж үзсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-аар хэрэгжүүлэхээр батлагдсан ажлын жагсаалтаас харахад урьдчилан эрэмбэлсэн ажлууд нь иргэдийн саналаар дэмжигдээгүйгээс жагсаалтаас хасагдсан байна.

2.2 Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлуудыг жагсаалтад оруулж сумын ИТХ-аар батлуулж хэрэгжүүлсэн байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-аар аймаг, сумын засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг боловсруулж ИТХ-д өргөн мэдүүлэх ба ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхөд журмын 6.3-т заасныг² баримтлахын зэрэгцээ “төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангаж ажиллана” гэж заасны дагуу иргэдээс санал авах, эрэмбэлэх үйл ажиллагааг шат шатанд зохион байгуулсан байна.

Иргэдийн санал авах эрэмбэлэх үйл ажиллагаанд дараах зөрчил дутагдлууд илэрч байна. Үүнд:

Сумдын ОНХС-ийн тухайд:

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч эрэмбэлсэн боловч дараах сумдад анхан шатны баримт материал байхгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт: 1

№	Сумдын нэр	Тайлбар
1	Алаг-Эрдэнэ	Санал асуулгын хуудас, анхан шатны баримт байхгүй байна.
2	Ханх	Санал асуулгын хуудас, анхан шатны баримт байхгүй байна.
3	Чандмань-Өндөр	Санал асуулгын хуудас, анхан шатны баримт байхгүй байна.
4	Цагаан-Үүр	Санал асуулгын хуудас, анхан шатны баримт байхгүй байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Журам”-ын 12.2.1а-заалтыг зөрчсөн байна.

² 6.3.3 хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх
6.3.6 зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр эх үүсвэртэй давхардуулахгүй байх

- Иргэдээс санал аваагүй ажлуудыг жагсаалтад оруулж сумын ИТХ-аар батлуулж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт:2

№	Сумдын нэр	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян,төг/
1	Арбулаг	Нийтийн хог хаягдал цэвэрлэгээ, үйлчилгээ	4361.0
2		Засаг даргын нөөц буюу гамшгаас хамгаалах зардал сургалт сурталчилгаа	5600.0
3	Галт	Сумын төвийн худаг ус нөөцлөх сав	5000,0
4		“Баг” хөтөлбөр	10000,0
5		Хүүхдийн цэцэрлэгийг ундны усны тоног төхөөрөмжөөр хангах	500,0
6		Байгаль хамгаалагчийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	537,0
7		“Ном” хөтөлбөрийн хүрээнд сумын Соёлын төвийн номын сангийн фонд нэмэгдүүлэх	3000,0
8	Жаргалант	Сумын ЭМТ-н эхчүүдийн амрах байрны засвар тохижилт	1400,0
9	Цагаан-Уул	Хүүхдийн цэцэрлэгийн камер	2000.0
10		Засаг даргын камер	2055.0
11		Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	8000,0
12	Чандмань-өндөр	Хадуурын үнэ	1500,0
13		Зам засварын ажил	1000,0
14		Хүүхэд гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	12000,0
15	Шинэ-Идэр	Сумын хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх	13660,8
16	Цэцэрлэг	Амралт сувиллын барилга	9900.0
17		Спорт заалны өргөтгөл	8000.0
18		Могойн бага сургуулийн засвар	3000.0
19		Зүтгэх хүчний машин	19000.0
20		Хүүхдийн цэцэрлэгийн гал тогооны өргөтгөл	9502.0
21		Хурдан морины гарааны төхөөрөмж худалдан авах	5000.0
22		Гудамжны хаягжуулалт	700.0
23	Цагаан-Үүр	Багийн засаг даргын мотоцикль	7000.0
24		Эрүүл мэндийн төв угаалгын байрны засвар	10000.0
25		Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр	22000.0
26		Соёл биеийн тамир спортыг дэмжих хөтөлбөр	4500.0
27		Булган багийн цэнхэр гүүрний засварын ажил	614.0
28		Дархинт багийн улаан булангийн засвар	100.0
29	Цагааннуур	Гамшигаас хамгаалах ой хээрийн түймрийн багаж тоног төхөөрөмж	5000.0
30		Багийн эмчийн унаа худалдан авах /Мотоцикль/	1500.0
31		Сургууль цэцэрлэгийн бүх анги, гал тогоо, ЗДТГ-ыг камержуулах	16500.0
32	Улаан-Уул	Хүдрэнтийн хорооллын гүний худаг засварлаж ашиглалтад оруулах	10000.0
33		Дархадын өв соёлын сурталчлах арга хэмжээ	5000.0
34		Төвийн доторх авто зам	9870.0
35	Аймгийн ОНХС	Гурван эрдэнэ ЕБС, Мөрөн 11 дүгээр цэцэрлэгийг нэгдсэн халаалтад холбох	51000,0
	Нийт		140555.8

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн саналаар төсөл арга хэмжээг нэмж жагсаалтад оруулж ИТХ-ын тогтоолоор баталж байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 заалт, “ОНХС-ийн заавар”-ын 4.2 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аймгийн ОНХС-ийн тухайд: 2016 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны урьдчилсан жагсаалт гаргаж, иргэдээр хэлэлцүүлэн санал авах арга хэмжээг зохион байгуулж 8 чиглэлд 24 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан байна.

Хэлэлцүүлэг хийж, санал авах ажлыг 24 сумын 53 багт 7448 иргэнийг оролцуулан санал авсан байна. Иргэдээс ирүүлсэн саналыг тоолж эрэмбэлэн аймгийн ИТХ-ын 2016.12.03-ны хуралдааны тогтоолоор баталсан байна.

ОНХС-ийн төлөвлөлттэй холбоотой дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- ТАХ-ээг хэлэлцүүлсэн санал асуулгын хуудас, ажлын баримтуудыг үдэж цэгцэлж архивын нэгж болгоогүй байна.
- Аймгийн ИТХ-ын 2016.12.03-ны тогтоолоор батлагдан хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтын 1.1.8-ын “Онцгой байдлын газар, 4 дүгээр цэцэрлэг, 24, 27 дугаар байрны гадна шугам сүлжээний дуусгалт” нэртэй ТАХ-ний нэршилд аймгийн ИТХ-ын 2016.04.06-ны 01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж “4-р цэцэрлэгийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох” гэж өөрчилсөн боловч аймгийн ИТХ-ын 2016.09.23-ны тогтоолд “Онцгой байдлын газар, 4 дүгээр цэцэрлэг, 24, 27 дугаар байрны гадна шугам сүлжээний дуусгалт” нэрээр тодотгол хийж батлуулсан байна.
- Жаргалант сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн “3-р багийн Бэлчирийн худаг завсар” төсөл арга хэмжээний 1548,5 мянган төгрөгийг “3-р багийн Огторын худаг завсар”-т зарцуулсан байна.

Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.25³-т заасантай нийцэхгүй байна.

2.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7⁴ дахь заалтын шаардлагыг хангаагүй нийт 335,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг батлахдаа зураг төсөвгүй, ТЭЗҮ хийгдээгүй, газрын болон техникийн тодорхойлолтгүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл арга хэмжээг баталсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 29 дүгээр зүйлийн 29.4, Сангийн сайдын 2014 оны 43 тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7, 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3, 12.2.5 заалтуудтай

тус тус нийцэхгүй байна. Үүнд:

№	Сумын нэр	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг /мян,төг	Тайлбар
1	Арбулаг	Сум багийн соёлын төвийн засвар, багийн ажлын албаны техник хэрэгсэл	6000.0	Зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй
2		Сум багийн соёлын төвийн тохижилт, багийн эмнэлэгийн тохижилт	6250.0	Ажлын даалгаваргүй, техникийн тодорхойлолтгүй.
3		Энгийн гар худаг засвар	800.0	Зураг байхгүй, ажлын даалгаваргүй
4		Сумын төвийн гүний худгийн засвар, эрүүл ахуйн стандартыг сайжруулах	1338.4	Зураг төсөв, ажлын даалгаваргүй
5		Засаг даргын нөөц буюу гамшгаас хамгаалах зардал сургалт сурталчилгаа	5600.0	Зураг төсөв, ажлын даалгаваргүй
6	Бүрэнтогтох	Гар худаг гаргах	3169.8	Зураг төсөвгүй
7		Туяа багийн Хядагын рашааны нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах	5000.0	Зураг төсөвгүй.
8		Сумын гудамж хорооллын гэрэлтүүлгийн засвар	1000.0	Ажлын даалгаваргүй
9	Чандмань-өндөр	Сумын төсвийн зам засварын ажил	25000,0	Зураг төсөв байхгүй
10		Ахмадын байрны өргөтгөл, алдрын танхим	6000,0	Зураггүй
11		Хүүхэд гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	12500,0	Зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлоогүй

³ Барилга, байгууламж, их засвар, тоног төрөөхөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршилыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах санхүүжүүлэхийг хориглоно

⁴ Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн бусад зөвшөөрөлтэй байх

12		Гэрэлтүүлэг нэмэлт ажил	9000,0	Ажлын даалгавар байхгүй
13	Шинэ-Идэр	Худаг засвар	2000,0	Техникийн тодорхойлолтгүй
14		Сумын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	13660,0	Зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлоогүй
15		2, 3-р багийн мал үзлэгийн хашаа барих	4000,0	Зураг төсөвгүй
16	Цагаан-үүр	ЭМТ-ийн угаалгын байрны засварын ажил	10000,0	Зураг төсөвгүй
17		Нийтийн халуун усны өргөтгөл	4400,0	Зураг төсөвгүй
18		Соёл, нийтийн биеийн тамир спортыг дэмжих хөтөлбөр	4500,0	Зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлоогүй
19		Багийн Засаг даргын мотоцикль	7000,0	Техникийн тодорхойлолт байхгүй
20	Цэцэрлэг	Спорт заалны өргөтгөл	8000,0	Зураг төсөвгүй
21		Хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөл	9502,0	Зураг төсөвгүй
22		Гудамжны хаягжуулалт	700,0	Зураг, ажлын даалгаваргүй
23		Могойн бага сургуулийн засвар	3000,0	Зураг төсөв, ажлын даалгаваргүй
24		ЕБС-ийн дотуур байрны цонх вакуумжуулах	12000,0	Зураг төсөв, ажлын даалгаваргүй
25		Соёлын төвийн шалны засвар	8000,0	Зураг төсөв, ажлын даалгаваргүй
26	Түнэл	ЕБС-д танхим байгуулах	4500,0	Техникийн тодорхойлолт байхгүй
27		Соёлын төвийн урд талбайг цементлэх	3000,0	Ажлын даалгавар байхгүй
28	Улаан-Уул	"Байц"-ын гүний худгийн засвар	26000,0	Техникийн тодорхойлолт байхгүй
29		Хүдрэнтийн хорооллын гүний худаг засварлаж ашиглалтад оруулах	10000,0	Техникийн тодорхойлолт байхгүй
30		Сумын төвийн зарим хэсгийг камержуулах	9712,0	Техникийн тодорхойлолт байхгүй
31		Эрчим хүчний өргөтгөл	5000,0	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар байхгүй
32		Дархадын өв соёлыг сурталчлах арга хэмжээ	5000,0	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар байхгүй
33		Төвийн доторх авто зам	9870,0	Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй
34	Жаргалант	Баг хөтөлбөр	10000,0	Зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлоогүй
35		Дөрөлж хорооллын худаг засвар	1000,0	Техникийн тодорхойлолт байхгүй
36		3-р багийн Өлөн завсар, сумын төвийн халуун усны худагт өрөмдлөгөө хийх	8500,0	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар байхгүй
37		4-р багийн зам засварын ажил	1500,0	Зураг төсөвгүй
38		Хүүхдийн цэцэрлэгийг ундны усны тоног төхөөрөмжөөр хангах	500,0	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар байхгүй
39		Байгаль хамгаалагчийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	537,0	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар байхгүй
40		Ном хөтөлбөрийн хүрээнд сумын Соёлын төвийн номын сангийн фонд нэмэгдүүлэх	3000,0	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар байхгүй
41		Сумын ЭМТ-ийн эхчүүдийн амрах байрны тохижилт	1400,0	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар байхгүй
42		Гурван эрдэнэ ЕБС, Мөрөнжин 11 дүгээр цэцэрлэгийг нэгдсэн халаалтад холбох	51000,0	ТЭЗҮ, төсөв хийгдээгүй
43	Аймгийн ОНХС	Мөрөн сумын гүний худгийн цэвэр усны нөөцийн сав солих	15800,0	Зураг төсөвгүй, техникийн тодорхойлолт байхгүй
	Нийт дүн		335739.2	

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад зураг төсөв хийгдээгүй, иргэдийн саналыг аваагүй төсөл, арга хэмжээ оруулсан нь ОНХС -ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2013-2015 онуудын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 1321500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй дараах төсөл арга хэмжээ иргэдэд үр ашгаа өгч эхлээгүй байна.

№	Сумын нэр	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг /мян.төг/	Тайлбар
---	-----------	-------------------	------------------------	---------

1	Арбулаг	Халуун усны өргөтгөл	42000.0	Ашиглалтын шаардлага хангаагүй, ашиглаагүй.
2	Бүрэнтогтох	Сумын төвийн худаг	3100.0	Ашиглаагүй.
3	Тосонцэнгэл	Сургуулийн халуун усны барилга -2014 он	25000,0	Ашиглаж эхлээгүй, зураг төсөв үндэслэлгүй хийгдсэнээс ашиглаж эхлээгүй.
4	Төмөрбулаг	Халуун усны барилга -2015 он	20000.0	Шатсан
5	Хатгал	Брэнд бүтээгдэхүүн худалдаалах цэг	100000.0	Халаалтын асуудлыг шийдээгүйгээс өвөл ажиллах боломжгүй, дулаан алдалт ихтэй.
6	Цагаан-Үүр	Багийн иргэний танхим	25000.0	Дуусаагүй, зураг төсөв нь шаардлага хангаагүй
7	Цагаан-Үүр	Фермер	70000.0	Үр ашгаа өгч эхлээгүй
8	Цагаан-Үүр	ЭМТ-ийн байрны засвар	10000.0	Зураг төсөвгүй, дуусаагүй
9	Чандмань-Өндөр	Халуун усны өргөтгөл	15000.0	Зураг төсөвгүй, ашиглаж эхлээгүй
10	Цагаан-Үүр	Халуун усны завсар	4500,0	Ажил нь дуусаагүй
11	Цагаан-Үүр	Универсаль трактор	97000,0	Ашиглаж эхлээгүй, мөнгөө бүрэн өгөөгүй, шүүхийн шатанд яваа
12	Цагааннуур	Халуун усны барилга	60000.0	Ашиглаагүй
13	Аймгийн ОНХС	Хөл бөмбөгийн талбай	800000,0	Бүрэн дуусаж ашиглалтад ороогүй
14	Галт сум	Халуун усны барилга	49900,0	Ашиглалтын шаардлага хангаагүй
	Нийт		1321500,0	

Дээрх ажлуудыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулах, маргаантай байгаа хөрөнгийг шийдвэрлэх **албан шаардлага** хүргүүлж байна.

2.4 Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд шинээр хэрэгжүүлсэн 231, өмнөх оноос шилжиж ирсэн 64 нийт 295 төсөл, арга хэмжээнээс 13 ажлыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй, 6 ажлыг олон нийтийн оролцоотой болон хязгаарлагдмал тендер, 75 ажлыг харьцуулалтын аргаар, 148 ажлыг шууд гэрээ байгуулах аргаар тус тус хэрэгжүүлсэн байна.

Зарим сумдын 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд дараах зөрчил дутагдал илэрч байна.

- Бүрэнтогтох, Чандмань-Өндөр сум 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, баримт материалыг архивын нэгж болгоогүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.1 (...Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална...) заалтыг зөрчсөн байна.

Бусад сум болон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга хэмжээг “төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна.

Сум орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн зам талбайг хамгаалах, сэргээх, гудамж талбайн гэрэлтүүлэг хийх, түүний засвар үйлчилгээ тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийх, явган хүний зам, талбай байгуулах, хог цэвэрлэх малжуулах,

нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, малын бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах, булаг шанд, ундны усны эх хамгаалах, худаг гаргах, бэлчээр хаших зэрэг холбогдох нарийн мэргэжил шаардахгүй энгийн ажлыг Сангийн сайдын 2014 оны “ОНХС-ийн заавар”-ын 8.3-т заасны дагуу Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулахад санаачлагатай ажиллахгүй байна.

2.5 ОНХС-ийн 19600,0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймаг сумдын хэмжээнд нийт 306 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 251 хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Нийт хэрэгжүүлсэн арга хэмжээнээс аймагт 7 хөтөлбөр, сумдад 6 хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-аар хэрэгжсэн Хөтөлбөрийн хүрээнд баяр наадам тэмдэглэх, шагнал урамшуулал олгох, хөрөнгө бэлтгэх зэрэгт зардал гаргаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.3⁵, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 4.4⁶, Засгийн газрын 2014 оны 147, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолд заасан хэмнэлтийн горимын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Аймагт хэрэгжсэн Хөтөлбөрүүдээс түүвэрлэн үзэхэд дараах байдалтай байна.
Тухайлбал:

“Аялал жуулчлал- ажилтай орлоготой Хөвсгөл” хөтөлбөрийн хүрээнд:

- + Хөх сувд-2016 арга хэмжээ зохион байгуулахад мөсөн урлан бүтээх уралдааны шагнал – 8000,0 мянган төгрөг зарцуулсан
- + Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах ажиллах хүмүүсийн урамшуулал, байр, хоол – 2000,0 мянган төгрөг
- + Соёл урлагийн арга хэмжээнд 2 өдөр оролцох техник хэрэгсэл, микрофон, мотор, өсгөгч хөгжим хариуцахад гарах – 2000,0 мянган төгрөг
- + Мөсний баяр зохион байгуулах ажлын хэсгийн байр, хоол- 1000,0 мянган төгрөг
- + Цаатан фестиваль зохион байгуулахад төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх холбогдох уралдаан тэмцээний зардал – 1000,0 мянган төгрөг
- + АЙ ТИ ЭМ – 2016 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох талбайн түрээс – 900,0 мянган төгрөг
- + АЙ ТИ ЭМ – 2016 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн стендийн зардал – 330,0 мянган төгрөг

“Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:

- + Зургийн аппарат – 1ш - 3000,0 мянган төгрөг
- + Хувилагч – 1ш - 5200,0 мянган төгрөг
- + Зөөврийн компьютер – 2ш- 3100,0 мянган төгрөг
- + Алсын зайн микрофон – 2ш – 500,0 мянган төгрөг
- + Проекторын суурь – 1ш – 100,0 мянган төгрөг гэх мэт нийт 12800,0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөрийн хүрээнд:

⁵ Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашины зан үйл болон ёслолын зардалд зарцуулахыг хориглоно

⁶ аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болох хөрөнгийн зардалд зарцуулахгүй

+ Эмнэлэгийн хэрэгсэл нийлүүлэх – 11000,0 мянган төгрөг

Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

- + Нэгдсэн эмнэлэгт цусны хурилтуур – 71000,0 мянган төгрөг байна.
- + Эмчилгээний тоног төхөөрөмж – 9900,0 мянган төгрөг
- + Ор дэрний ком зөөлөн эдлэл - 1210,0 мянган төгрөг
- + Нэгдсэн эмнэлэгт ажиллах хөтөч – 3600,0 мянган төгрөг

2016 онд шинээр хэрэгжүүлсэн дараах төсөл арга хэмжээнд ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

- + Арбулаг сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Засаг даргын нөөц буюу гамшгаас хамгаалах зардал сургалт сурталчилгаа” төсөл арга хэмжээнд 5600.0 мянган төгрөгийг зарцуулсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын сумын хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцэхгүй байна.
- + Жаргалант сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Сумын ЭМТ-ийн эхчүүдийн амрах байрны тохижилт” нэртэй төсөл арга хэмжээний 1400,0 мянган төгрөгийг ЭМТ-ийн пургон машины сэлбэг авахад зарцуулсан байна.
- + Жаргалант сумын Баг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн “Сумын ЭМТ-ийн амбулторын барилгыг тохижуулан засвар хийх” ажлын 7600,0 мянган төгрөгөөс 4600,0 мянган төгрөгийг хандиваар барьсан байшингийн палк нийлүүлсэн өрөнд гүйцэтгэгч компани суутгаж авсан байна.
- + Шинэ-идэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Техник эдийн засгийн тооцоолол” төсөл арга хэмжээнд батлагдсан хөрөнгөөс 2000,0 мянган төгрөгийг концессын гэрээгээр хийгдсэн “150 хүүхдийн цэцэрлэг”-ийн барилгын хөрсний шинжилгээний үнэд зарцуулсан байна.
- + Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Цагаан-үүр сумын “Дөрөлжийн давааны зам засвар”-ын ажлын зураг төсвийн үнэд 2014 оны сумын ОНХС-аас 6000,0 мянган төгрөгийг “Дүгийн эх” ХХК-д шилжүүлсэн байна. Гэтэл дээрх ажлын зураг төсвийг 2015 онд “Классик роуд” ХХК хийж 11840,0 мянган төгрөгийг 2015.07.17-нд замын сангаас шилжүүлэн авсан байна.

Зориулалт бусаар зарцуулсан дээрх төсөл арга хэмжээний нийт 19600,0 мянган төгрөгийг буцаан ОНХС-ийн эх үүсвэр болгож төвлөрүүлэх **төлбөрийн акт тогтоож** байна.

- + Цагааннуур сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Гүний худаг” нэртэй төсөл арга хэмжээ тухайн онд ажил нь огт хийгдээгүй байхад 5805,0 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компанид төлбөрийн хүсэлт, анхан шатны баримтгүйгээр төрийн сангийн мэргэжилтэн шилжүүлэн олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, Сангийн сайдын 2005 оны 123 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн төлбөр тооцооны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3⁷ дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Иймд тус сумын төрийн сангийн мэргэжилтэнд “Төрийн

⁷ 7.3. Төрийн сан төсвийн байгууллагын ирүүлсэн хүсэлтийг хянаж шаардлага хангасан гэж үзвэл ТТ-1 маягтаар хийх төлбөрийн баримтын 3 дугаар хувийг, ТТ-2 маягтаар хийх бэлэн мөнгөний төлбөрийн баримтын 2 дугаар хувь, анхан шатны болон үндэслэх баримтуудад Төрийн сангийн мэргэжилтэн гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулан Төсвийн байгууллагад өгнө.

сангийн төлбөр тооцооны журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1⁸-д заасны дагуу хариуцлага тооцох санал хүргүүлж байна.

2.6 Ихэнх сумууд нь төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үр дүнтэй тавихгүй байна.

ОНХС-ийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгаагүй, захиалагч ажлын гүйцэтгэлийн явцад хяналт хийгээгүй, барьцаа хөрөнгийг хуульд заасан хэмжээгээр байршуулаагүй зөрчил илэрч байна. Тухайлбал хүснэгтээр харуулбал:

№	Сумдын нэр	Захиалагчийн хяналтын зардлыг төвлөрүүлсэн дүн	Захиалагч хийсэн эсэх хяналт	Барьцаа хөрөнгө авч үлдсэн эсэх
1	Алаг-Эрдэнэ	0	Үгүй	0
2	Арбулаг	0	Үгүй	0
3	Баянзүрх	0	Үгүй	0
4	Бүрэнтогтох	1568.6	Тийм	0
5	Галт	1299.0	Тийм	1321.6
6	Жаргалант	0	Үгүй	0
7	Их-Уул	0	Үгүй	2365.0
8	Рашаант	0	Үгүй	0
9	Ренчинлхүмбэ	2313.7	Үгүй	748.0
10	Тариалан	0	Үгүй	0
11	Тосонцэнгэл	1280.0	Тийм	0
12	Төмөрбулаг	181.8	Тийм	854.5
13	Түнэл	394.9	Үгүй	2500
14	Улаан-Уул	0	Үгүй	0
15	Ханх	1266.4	Тийм	0
16	Цагааннуур	0	Үгүй	1387.5
17	Цагаан-Уул	0	Үгүй	0
18	Цагаан-Үүр	464.8	Тийм	0
19	Цэцэрлэг	0	Үгүй	0
20	Чандмань-Өндөр	0	Үгүй	0
21	Шинэ-Идэр	0	Үгүй	0
22	Эрдэнэбулган	0	Тийм	0
23	Хатгал	0	Үгүй	0
24	Мөрөн	1548,9	Тийм	8886,4
25	Аймгийн ОНХС	8051,0	Тийм	43670,2
	Нийт дүн	18369.1		61733.2

Дээрх хүснэгтээс харахад сумдын хувьд Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагнал”-ын журмын дагуу захиалагчийн хяналт, барьцаа хөрөнгийг гэрээнд тусгаж, гүйцэтгэлд үр дүнтэй хяналт тавьж хэвшээгүй байна.

Ханх сумын “Эрүүл мэндийн төвийн засварын ажил”-ын чанарын баталгааны барьцаа хөрөнгө болох 3205.3 мянган төгрөгийг 3 жилийн хугацаатай, Түнэл сумын “1-р багийн Иргэний танхим шинээр барих” төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгө болох 975.0 мянган төгрөгийг 1 жилийн хугацаатай, Шинэ-Идэр сумын “Хогийн цэгийн тохижилтын ажил гүйцэтгэх” төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгө болох

⁸ 8.1 Төрийн сангийн ажилтан нь төсвийн эрхийг байгууллагын дансны үлдэгдэл, зарцуулалтын эрхийн баталгааг хэтрүүлэн олгосон эсвэл Төрийн сангийн холбогдох дүрэм журмыг ноцтой зөрчсөн нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

1420.0 мянган төгрөгийг 2 жилийн хугацаатайгаар тус тус байршуулна гэж гэрээнд тусгасан байхад барьцаа хөрөнгийг авч үлдэлгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон зөрчил байна.

Аймгийн ОНХС-ийн хувьд гэрээнд заасан хувь хэмжээгээр захиалагчийн хяналтын зардлыг төвлөрүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар ажил тус бүр дээр төслийн менежерийн багийг томилсон байна.

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Төслийн менежер
1	Мөрөн сумын хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн бохир усыг нэгдсэн шугамд холбох ажил	“Титэмт барилга трейд” ХХК	Ж.Ганболд –АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
2	Мөрөн сумын өрхийн эмнэлэгүүдэд центрбуг багаж төхөөрөмж нийлүүлэх ажил	“Монс фарм” ХХК	Ж.Ганболд – АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
3	Мөрөн сумын усан сангийн байгууламжийн өргөтгөлийн ажил	“Уул-Өвгөд” ХХК	Н.Бямбадорж – ГХБХБГ-ын дарга
4	Мөрөн сумын гэрэлтүүлэг сайжруулах	“Анд-Энерги” ХХК	Ц.Ганболд –Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүн
5	Аялал жуулчлал-Ажилтай орлоготой Хөвсгөл хөтөлбөр	-	Г.Энхбаяр – ХБХ-ийн мэргэжилтэн
6	Мөрөн сумын нийтийн байруудын гадна тохижилтын ажил	“Модерн хас” ХХК, “Төмөрт хос бэрс” ХХК, “Ханилцаг” ХХК	А.Цэрэндулам – ХААА-ны ахлах мэргэжилтэн
7	Өрх гэр бүлийн хөгжил хөдөлмөр эрхлэлт хөгжлийг дэмжих хөтөлбөр	“Хөвсгөл Тэвхэн” ХХК, “Хөвсгөл Хонгор” ХХК	Ж.Ганболд – АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
8	Иргэний оролцоо нээлттэй засаглал хөтөлбөр	-	Х.Цэнд-Аюуш – АЗДТГ-ын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга
9	Мөрөн сумын гүний худаг, усан сангуудын цэвэр усны нөөцийн сав шинэчлэх	“Голден прогресс” ХХК	Г.Энхбаяр – ХБХ-ийн мэргэжилтэн
10	Иргэний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр	-	Г.Гандэлгэр – АЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн дарга
11	Оюунлаг хөвсгөл хөтөлбөр	-	Ж.Ганболд – АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
12	Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр	-	Ж.Ганболд – АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
13	Гурван эрдэнэ ЕБС, 11 дүгээр цэцэрлэгийг нэгдсэн халаалтад холбох ажил	“Хөвсгөл Монтрейвэл” ХХК	Б.Энхжаргал – ГХБХБГ-ын мэргэжилтэн
14	Мөрөн сумын хөл бөмбөгийн талбай байгуулах ажил	“Дэрэн наран” дуусгалт ХХК	Б.Баярсайхан – БТС-ын газрын дарга
15	Онцгой байдал, 4-р цэцэрлэг, 24,27 дугаар байруудыг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох	“Эв ухаат” ХХК	О.Төмөрхуяг – Хөвсгөл дулааны станцын ерөнхий инженер
16	Мөрөн сумын шинэ суурьшилын бүсийн цахилгаан эрчим хүчний хангамжийг бий болгох ажил /Хөх толгой/		Б.Болд – АЗДТГ-ын дэргэдэх ХААА-ны дарга

17	Аялал жуулчлалын бүсэд орон нутгийн брэнд бүтээгдэхүүн борлуулах зориулалтаар барих барилгын ажил		Ж.Ганболд – АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
18	Цаг уурын мэдээлэл хэмжил судалгааг сайжруулах хөтөлбөр	“Хөвсгөл тэнхлэг” ХХК	Ч.Уртнасан – АЗДТГ-ын ХШҮ-ний тасгийн дарга

2.7 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлд тусган ажиллаж байна.

ОНХС-ийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан маягт, аргачлалын дагуу гаргасан байна. Сумдын ОНХС-ийн тайланг тусад нь гаргаж, сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэж тайлагнасан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 8.6-д заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэн ажилласан байна.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн ОНХС-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн аудит хийж “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна. Сумдын ОНХС-ийн 2016 оны санхүүгийн тайланг төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хамруулан шалгахад Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагнал”-ын журмыг баримтлан, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг захиалагчаар дамжуулаагүй шууд гүйцэтгэгчид шилжүүлсэн, өр, авлагыг тооцоо нийлээгүй гэх мэт 313,1 сая төгрөгийн зөрчил дутагдалд зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

БҮЛЭГ-3. Шат шатны ИТХ-аас ОНХС-д тавих хяналтыг үр дүнтэй хийж чадахгүй байна.

Үндсэн мэдээлэл:

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталагдсан “Заавар”-ын 9.1-д заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад шат шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, Санхүүгийн хяналт, аудитын алба хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

Шат шатны ИТХ-аас тавих хяналтыг шалгахад “Хяналтын хороо”-г байгуулсан боловч 2016 оны ОНХС-д үр дүнтэй хяналт хийж, нийтэд ил тод мэдээлж хэвшээгүй байна. Аудитаар ажилласан сумдын 33% нь 2016 оны ОНХС-д хяналт хийсэн байна. Аудитын явцад зөвлөмж өгсөний дагуу аймгийн ИТХ нь ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор хяналтын хороог байгуулсан байна. Хяналтын хороо нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийж дараах дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

- ❖ Орон нутгийн иргэдийн санал хүсэлтээр хийгдсэн эдгээр ажлуудын засвар, арчлалт, хамгаалалтыг цаашид тодорхой болгож, хийгээд орхих биш байнгын хараа хяналттай, эзэнтэй, үр ашгийг нь нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байгаа нь дээрх төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнтэй танилцаж байхад харагдаж байна.

- ❖ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжихээр батлагдсан нэр бүхий 7 хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн тодорхой бус байгаад анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.
- ❖ Эдийн засгийн тооцоололгүйгээр хийгдсэн зарим ажлууд дээр дахин техник эдийн засгийн үндэслэлийг боловсронгуй болгож хөрөнгийг үр ашигтай зарцуулах.
- ❖ Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагддаг төслийн менежерийн багийг үр дүнтэй ажиллуулах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасан хугацаанд ажлыг эхлүүлэх, дуусгах, бодитой дүгнэж байх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй /Менежерийн багт төлөөлөгчдийг оролцуулах/ гэх мэт дүгнэлтүүд хийсэн байна.

3.1 16 сумын ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад дараах 7 сум хяналт тавьж ажилласан байна. Үүнд:

- ❖ Арбулаг сум
- ❖ Төмөрбулаг сум
- ❖ Цагаан-Уул сум
- ❖ Чандмань-Өндөр сум
- ❖ Шинэ-Идэр сум
- ❖ Мөрөн сум
- ❖ Эрдэнэбулган сум

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1⁹, 9.4¹⁰ дэх заалтуудын дагуу аймгийн ОНХС болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад шат шатны ИТХ хяналт тавьж ажиллаагүй байна.

ОНХС-ийн зааврын 9.1, 9.4 дэх заалтыг зөрчсөн нийт 16 сумын ИТХ-ын дарга нарт албан шаардлага хүргүүлээ. **Графикаар харуулбал:**



Шат шатны ИТХ, аймгийн Санхүү, хяналт дотоод аудитын албанаас аймаг сумын ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтад хяналт, үнэлгээг үр дүнтэй хийгээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаж чадахгүй байгаагаас өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй ба зөрчил дутагдал өмнөх онуудаас нэмэгдсэн байна.

⁹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана

¹⁰ Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж үнэлгээ хийнэ

3.2 Ажлын хэсэг байгуулж, сумдын тухайн жилийн ОНХС-ийн тайланд дүн шинжилгээ хийж хэвшээгүй байна.

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсээс ОНХС-ийн зарцуулалт, гүйцэтгэлийн талаар дараах зөвлөмж, мэдээллийг хийсэн байна.

- Аймаг сумдын хэмжээнд 2016 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын жагсаалт гаргаж, Засаг даргын зөвлөлийн хуралд оруулахад бэлтгэж, бүх хяналтын байгууллагад хүргүүлсэн.
- 2016 оны ОНХС-д үүссэн өр авлагыг нэгтгэж, 2017 онд шинээр ажил нэмж батлахгүй, өмнөх оны өрийг барагдуулж ажиллах талаар сумдын удирдах ажилтны зөвлөгөөн дээр мэдээлэл хийсэн
- Тогтвортой амьжиргаа – 3 төслөөс ОНХС-ийн баримт материалд хяналт шалгалтыг 23 сум, 1 тосгонд явуулсан байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 10.1¹¹ дэх заалтын дагуу дараах ажлууд хийгдээгүй байна.

Үүнд:

1. Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулаагүй байна.
2. ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг сумдаас жил бүрийн 7 дугаар сарын 10-ний дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор хүлээн авч дүн шинжилгээ хийгээгүй байна.

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга болон ОНХС-ын хариуцсан мэргэжилтэн нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 10.1 дэх заалтын дагуу сумдаас тайлан мэдээг хугацаанд нь шаардан авч, зөрчил дутагдлуудыг илрүүлэн, түүнийг арилгах зөвлөмж хүргүүлж ажиллаагүй байна.

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт, гүйцэтгэсэн төсөл арга хэмжээ, түүний худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүр shilendans.gov.mn, mof.gov.mn цахим хуудсанд мэдээлж байна.

Аймгийн ОНХС болон 21 сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд нийтэд ил тод, үнэн зөв мэдээлсэн байна.

Дараах сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд алдаа зөрчилтэй, дутуу мэдээлж байна. Шилэн дансны тухай хуулийн 6.3.9 (...Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл...)–д заасан сар, улирлын мэдээллийг дараа сарын 08-ны дотор тогтмол мэдээлнэ гэсэн заалтыг зөрчсөн байна. **Хүснэгтээр харуулбал:**

¹¹ Сумын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажлуулна.

№	Сумын нэр	Шилэн данстай холбоотой зөрчлийн тайлбар
1	Түнэл	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд мэдээлээгүй
2	Ханх	ТАХ-ний санхүүжилтийн мэдээллийг өссөн дүнгээр мэдээлээгүй, үнийн дүнг буруу мэдээлсэн байна.
3	Цэцэрлэг	8-12 дугаар саруудын мэдээллийг мэдээлээгүй, 1-8 дугаар саруудад хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Дээрх сумдын санхүүгийн албаны дарга нарт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд тогтмол шуурхай үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгч ажиллаа.

3.4 Төсвийн тухай хуулинд 2016 онд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан ОНХС-ийн “Заавар”-ыг өөрчлөх шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30¹² дугаар заалтад тусгайлан заасан орон нутгийн суурь зарлагад хуулийн дагуу хамаарахгүй боловч зайлшгүй санхүүжигдэх дараах зардлуудыг аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр санхүүжүүлж болохоор зохицуулалт хийгдсэн. Үүнд:

- Аймгийн /дүүргийн, сумын/ нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх томоохон хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж, талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах /Нийслэлээс бусад
- Мал амьтаны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавьжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх, мал эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх
- Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх /Нийслэлээс бусад/
- Усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх

Төсвийн тухай хуулийн өөрчлөлт болон бусад холбогдох хуулинд гарсан өөрчлөлтөд нийцүүлэн “Заавар”-ыг өөрчлөх нь зүйтэй байна.

3.5 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт хэрэгжээгүй, албан шаардлагын хэрэгжилт 50%, зөвлөмжийн хэрэгжилт 60,9% байна.


Өмнөх онд хийгдсэн нийцлийн аудитаар 4 албан шаардлага, 2 акт, холбогдох албан тушаалтанд 16 зөвлөмж хүргүүлсэн байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 60,9%-ийн биелэлттэй байгаа ба зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхгүйгээс үүдэн өмнөх онуудаас зөрчил дутагдал нэмэгдсэн байна.

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг биелүүлээгүй төрийн албан хаагчдад Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т зааснаар хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж байна. /Хавсралт3/-аас харах

¹² 4.1.30. “орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж энэ хуулийн 58.1.1, 58.2.1, 58.3.1, 58.4.1-д заасан чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, энэ хуулийн 58.1.4, 58.1.14, 58.2.4, 58.2.13, 58.3.2, 58.3.5, 58.4.2, 58.4.6-д заасан чиг үүрэгтэй холбогдох урсгал зарлагын нийлбэрийг;


Санал асуулгын талаар: Нийцлийн аудитаар 15 сумдын нийт 780 иргэнийг хамруулсан санал асуулга явуулсан болно. Санал асуулгын дүн дараах байдалтай байна.

1. ОНХС-н санхүүжилтийн ямар ТАХ танай хороо, суманд хэрэгжиж буй талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?




Санал асуулгад оролцсон иргэдийн 51% нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ээг сайн мэддэг гэсэн дүгнэлт гарсан байна.

2. ОНХС-н асуудлыг хэлэлцэх баг, хорооны ИНХ-д та оролцож байсан уу?




Санал асуулгад оролцсон иргэдийн 48,9% нь ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх баг, хорооны ИНХ-д хааяа оролцдог гэсэн байна.

3. Хэрвээ оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлуудыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар таны бодол.




ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэдээр хэлэлцүүлэхдээ цаанаа бэлтгэсэн төсөл арга хэмжээг биш оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг үү? гэсэн асуултад 36,1% нь тийм гэж хариулсан байна.


4. ОНХС-н санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон ТАХ-ний талаарх мэдээллийг зарладаг уу?



5. ОНХС-с ямар ТАХ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас танай өрхөд ирж байсан уу?



6. ОНХС-н санхүүжилтээр хэрэгжүүлж буй ТАХ-ний хэрэгжилт, ашиглалтад иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юу?



Нийцлийн аудитаар нийт 1807.6 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч, түүнээс 19,6 сая төгрөгийн акт тогтоож, 17 албан шаардлагыг хүргүүлж ажилласан болно.

ДҮГНЭЛТ

1. ОНХС-ийн орлогын шилжүүлэгт хасах тодотгол хийсэнтэй холбогдуулан зарим сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох өрийг төлөх боломжгүй болсон, ИТХ-аар батлагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бололцоо алдагдсан зэрэг сөрөг талууд үүсч эхэлсэн байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад зураг төсөв хийгдээгүй, иргэдийн саналыг аваагүй төсөл, арга хэмжээг ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн нэмж оруулсан нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх, хууль журам зөрчихөд хүргэсэн байна.
3. ОНХС-ийн хөрөнгийг ИТХ-аар батлагдаагүй төсөл арга хэмжээнд зарцуулсан, тухайн жилд ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын нэр байршил солигдсон байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр сум орон нутагт бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна.
5. Шат шатны ИТХ, аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймаг сумын ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтад хяналт, үнэлгээг үр дүнтэй хийгээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаж чадахгүй байгаагаас өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй, зөрчил дутагдал өмнөх онуудаас нэмэгдсэн байна.
6. Аймаг, сумдын ОНХС-ийн мэдээллийг холбогдох цахим хуудас болон мэдээллийн самбараар ил тод мэдээлж хэвшсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатарт:

1. Иргэдийн саналаар дэмжигдсэн, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 4.7-д заасан шаардлагыг хангасан хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцэн баталж байх
2. Аймгийн ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт үнэлгээг чанартай хэрэгжүүлж нийтэд ил тод мэдээлж байх

Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д:

3. Иргэдийн саналаар дэмжигдсэн, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 4.7-д заасан шаардлагыг хангасан хөтөлбөр төсөл арга хэмжээг төлөвлөж байх
4. ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадам тэмдэглэх, урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх
5. 2013-2015 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн барилга байгууламжуудыг ашиглалтад оруулж, үр ашгийг иргэдэд хүртээх ажлыг зохион байгуулах
6. Аймаг сумдад хэрэгжиж байгаа ОНХС-ийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн, хяналт аудитын албаар хяналт хийлгэж, зөрчлийг арилгаж байх

Аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Аззаяа-д:

7. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлыг иргэдээр хэлэлцүүлсэн ажлын баримт материалыг цэгцэлж, архивын нэгж болгох
8. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 10.1 дэх заалтад заасан хугацаанд сумдаас тухайн жилийн ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг авч үнэлгээ хийж, үр дүнг Засаг дарга, орон нутгийн удирдлагуудад танилцуулж байх

Сумдын ИТХ-ын дарга нарт:

9. Иргэдийн саналаар дэмжигдсэн, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 4.7-д заасан шаардлагыг хангасан хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцэн батлах
10. Сумдын ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт үнэлгээг чанартай хэрэгжүүлж ил тод мэдээлж байх

Сумдын Засаг дарга нарт:

11. Иргэдийн саналаар дэмжигдсэн, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 4.7-д заасан шаардлагыг хангасан хөтөлбөр төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгах
12. ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадам тэмдэглэх, урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх
13. Сүүлийн жилүүдэд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн барилга байгууламжуудыг ашиглалтад оруулж, үр ашгийг иргэдэд хүртээхэд анхаарч ажиллах

ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Нэг. Акт

№	Сум	Төлбөр хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Актын дугаар	Зөрчлийн дүн /мян,төг/
		Нэр	Албан тушаал			
1	Арбулаг	К.Намхайжанцан , Б.Цэндбаяр, Г.Дэлгэрцэцэг	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга, Нягтлан бодогч	Арбулаг сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Засаг даргын нөөц буюу гамшгаас хамгаалах зардал сургалт сурталчилгаа” төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын сумын хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцэхгүй байна.	ҮАГ/НАГ/201 7/01-НА- ХөААГ-01/02	5600,0
2	Жаргалант	Д.Батбаатар, Б.Ундармаа, Б.Энх-жаргал	ЗДТГ-ын дарга, Санхүүгийн албаны дарга, ЗДТГ-ын ня-бо	Жаргалант сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн “сумын ЭМТ-ийн эхчүүдийн амрах байрны тохижилт” нэртэй төсөл арга хэмжээнд зориулах хөрөнгийг ЭМТ-ийн пургон машины сэлбэг авахад зарцуулсан байна.	ҮАГ/НАГ/201 7/01-НА- ХөААГ-02/03	1400,0
				Жаргалант сумын Баг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн “Сумын ЭМТ-ийн амбулторын барилгыг тохижуулан засвар хийх” ажлын 7600,0 мянган төгрөгөөс 4600,0 мянган төгрөгийг хандиваар барьсан байшингийн палк нийлүүлсэн өрөнд гүйцэтгэгч компани суутгаж авсан байна.	ҮАГ/НАГ/201 7/01-НА- ХөААГ-03/04	4600,0
3	Шинэ-идэр	Т.Гомбосүрэн, А.Цогзол	Засаг дарга, ЗДТГ-ын ня-бо	Шинэ-идэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Техник эдийн засгийн тооцоолол” нэртэй төсөл арга хэмжээнд батлагдсан хөрөнгөөс концессын гэрээгээр хийгдсэн “150 хүүхдийн цэцэрлэг”-ийн барилгын хөрсний шинжилгээний мөнгө олгосон.	ҮАГ/НАГ/201 7/01-НА- ХөААГ-04/05	2000,0
4	Цагаан-үүр	Б.Далай, Д.Цогт- эрдэнэ Б.Тэгшжаргал	Засаг дарга, ЗДТГ-ын дарга, Б.Тэгшжаргал	Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Цагаан-үүр сумын “Дөрөлжийн давааны зам засвар”-ын ажлын зураг төсвийн үнийг “Дүгийн эх” ХХК-д шилжүүлсэн байна. Гэтэл дээрх ажлын зураг төсвийг 2015 онд “Классик роуд” ХХК хийж	ҮАГ/НАГ/201 7/01-НА- ХөААГ-05/06	6000,0

				11840,0 мянган төгрөгийг 2015.07.17-нд замын сангаас шилжүүлэн авсан байна.		
Нийт дүн						19600,0

Хоёр. Албан шаардлага

№	Аймаг, Сум	Төлбөр хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
		Нэр	Албан тушаал			
1	Хөвсгөл аймаг	Л.Ганболд	Засаг дарга	ОНХС-ийн хөрөнгөөр 2013-2015 онуудад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр арга хэмжээнүүд одоог хүртэл үр өгөөжөө өгөөгүй, ашиглаж эхлээгүй байна.	ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-17/19	1321500.0
2	Алаг-Эрдэнэ	Ж.Даваадамдин	ИТХ-ын дарга	ОНХС -ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад ИТХ хяналт тавьж ажиллаагүй байна.	ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-03/05	
3	Баянзүрх	Д.Нямдэлгэр	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-01/03	
4	Бүрэнтогтох	Д.Ренчиндорж	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-04/6	
5	Галт	И.Амгаланбаатар	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-5/7	
6	Жаргалант	Б.Должинсорогдог	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-6/8	
7	Их-уул	Б.Лхагважав	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-8/10	
8	Рашаант	Д.Мөнхжаргал	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-11/13	

9	Ренчинлхүмбэ	Ж.Дамбасүрэн	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-16/18	
10	Тариалан	Ё.Батзориг	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-02/4	
11	Тосонцэнгэл	Б.Уламбаяр	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-10/12	
12	Түнэл	Ж.Самбаллхүндэв	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-12/14	
13	Улаан-уул	Б.Бүрэнчөдөр	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-13/15	
14	Ханх	Л.Дуламхүү	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-07/09	
15	Цагаан-үүр	Н.Мягмарсүрэн	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-09/11	
16	Цагаан-нуур	С.Навчаа	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-15/17	
17	Цэцэрлэг	Ч.Дашдаваа	ИТХ-ын дарга		ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-14/16	
Нийт дүн						1321500.0

Гурав. Бусад

№	Сум	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /мян,төг/
1	Цэцэрлэг	Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.7-д заасны дагуу ОНХС-ийн тухайн жилийн зарцуулагдаагүй үлдэгдэл буюу худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг дараа жилийн ОНХС-ийн эх үүсвэр болгож батлуулаагүй.	2467,0
2	Сумууд	Иргэдээс санал аваагүй ажлуудыг жагсаалтад оруулж сумын ИТХ-аар батлуулж хэрэгжүүлсэн байна.	140555.8
3	Аймаг, сумууд	“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.	335739,2

4	Аймаг, Сум	2013-2015 онуудын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн дараах төсөл арга хэмжээ өдий хүртэл иргэдэд үр ашгаа өгч эхлээгүй, бүрэн ашиглалтад ороогүй байна.	1321500.0
5	Бүрэнтогтох, Чандмань-өндөр, Түнэл, Жаргалант	Бүрэнтогтох, Чандмань-Өндөр сумдын 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэхийг нотлох баримт материал байхгүй, архивын нэгж болгоогүй, цахимаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан гэх боловч холбогдох баримт материал байхгүй байна.	
6	Аймаг, сумууд	Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын дагуу захиалагчийн хяналт, барьцаа хөрөнгийг гэрээнд тусгаж, хугацаанд нь бүрэн байршуулаагүй. Төслийн менежерийг багийн ажил тус бүр дээр байгуулж байгаа боловч үе шатны хяналтыг үр дүнтэй хийж хэвшээгүй байна.	
7	Жаргалант	Жаргалант сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн “3-р багийн Бэлчирийн худаг завсар” нэртэй төсөл арга хэмжээний нэр байршил солигдож “3-р багийн Огторын худаг завсар”-т зарцуулсан байна.	1548,5
8	Цагааннуур	Цагааннуур сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Гүний худаг” нэртэй төсөл арга хэмжээний тухайд тухайн онд гэрээнд заасан ажил нь огт хийгдээгүй байхад гүйцэтгэгч компанид төлбөрийн хүсэлт, анхан шатны баримтгүйгээр мөнгө олгосон байна.	5805,0
9	Аймаг, Жаргалант	ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулсан, хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээний нэр, байршил солигдсон.	
10	Ихэнх сумдад	Шат шатны ИТХ, санхүү хяналт аудитын албанаас хэрэгжүүлэх хяналт хангалтгүй байна.	
11	Аймаг сумдууд	Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.	
Нийт дүн			1807615.5

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

67123 Мөрөн, Хөвсгөл аймаг

Утас: 70333283

www.khovsgol.gov.mn

2017.04.28

№

6/949

Танай

2017.04.28

Ны №

6/401

Санал хүргүүлэх тухай

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮДЭХ
АУДИТОР Г.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

Ах /ар. Б.П. нэгдүгээрт
1. Төсвийн
2. Саналыг
хон үргэж
баталгаажуулна.
2017-05-01

"Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт" нийцлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Гурван-Эрдэнэ ЕБС, Мөрөнжин 11 дүгээр цэцэрлэгийг нэгдсэн халаалтад холбох ажил, Мөрөн сумын гүний худгийн цэвэр усны нөөцийн сав солих ажлуудын ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөвгүй техникийн тодорхойлолт байхгүй иргэдийн саналыг аваагүй гэсэн байна. Дээрх 2 ажлын техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөвтэй дээрх ажлуудын ТЭЗҮ, зураг төсвийг аудитын байгууллагад хүргүүлсэн болно. Гурван-Эрдэнэ ЕБС, Мөрөнжин 11 дүгээр цэцэрлэгийг нэгдсэн халаалтад холбох ажил нь АИТХХ-аас шууд тусгагдан тогтоолд орсон ажил учир дээрх 2 ажлыг хасуулах саналтай байна.

Санал-1

Мөрөн суманд баригдаж байгаа хөл бөмбөгийн талбайг улсын комисс хүлээж аваагүй байгаа хэдий ч олон удаагийн уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгуулсныг Аймгийн биеийн тамир спорт хорооны газар батлах болно. Иймд уг арга хэмжээг иргэдэд үр ашигаа өгч эхлээгүй гэсэн жагсаалтаас хасуулах саналтай байна.

Санал-2

Баяр наадам тэмдэглэх, шагнал урамшуулал олгох, хөрөнгө бэлтгэх зэрэг зардалд төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.3 дахь заалтыг зөрчсөн гэж үзэж байгаад санал нийлэхгүй байна.

Санал-3

Хуулийн заалт: /60 дугаар зүйлийн 60.3.3 үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал/

Монгол орны өвлийн аялал жуулчлалын маршрутад орсон "Хөх сувд-2016" олон улсын эвент арга хэмжээг баяр наадам, ойн арга хэмжээтэй зүйрлэх боломжгүй юм. Аймаг орон нутаг төдийгүй олон улсын эвент арга хэмжээ болон өргөжөөд байна. "Хөх сувд-2016" эвент арга хэмжээг улам бүр өргөжүүлэх зорилгоор Оросын холбооны улс, БНХАУ, Монгол орны мөсөн сийлбэрчид оролцон мөсөн хотхон бүтээх ажлыг аймаг орон нутгаас санхүүжүүлсэн. Мөн Монгол улсын ерөнхийлөгч болон бусад төрийн өндөр дээд албан тушаалтнууд энэхүү арга хэмжээнд оролцсон. Цаг агаарын хүндрэлтэй цасан шуургатай байсан тул тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах албан хаагчдын хүчийг нэмэгдүүлэн ажилласны үр дүнд ямар нэгэн осол аваар гаргаагүй.


Эдгээр ажилчдын байр хоолны зардлыг гаргаснаас шагнал урамшуулалд тайлангийн төсөлд дурьсан шиг урамшуулал олгоогүй болно.

Цаатан фестиваль нь аялал жуулчлалын улирлын хамгийн гол гадаад дотоодын жуулчдыг татах арга хэмжээ. Үндэсний цөөнх болсон цаатан иргэдийн аж амьдралыг олон нийтэд сурталчилсан нутгийн иргэдийн ашиг орлогыг нэмэгдүүлсэн аялал жуулчлалын томоохон арга хэмжээний нэг учраас аймгийн Засаг даргын Тамгын газраас санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Энэ арга хэмжээг ямар нэгэн баяр наадам гэж үзэхээс илүүтэй орон нутгийн ашиг орлогыг нэмэгдүүлсэн томоохон эвент арга хэмжээ гэж үзэх нь зүйтэй.

Монголын аялал жуулчлалын хамгийн том үзэсгэлэн болох "Mongolia International travel Mart" аялал жуулчлалын үзэсгэлэн 2009 оноос эхлэн жил бүрийн 3-р сард зохион байгуулагддаг. Үзэсгэлэнд жуулчны баазууд тус, тусдаа талбай авч сурталчилгаа хийдэг байсан бол 2013 оноос эхлэн аймгийн ЗДТГ, аялал жуулчлал эрхлэгчдийн холбоо хамтран нэгдсэн байдлаар оролцдог болсон.

Mongolia "ITM-2016" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймаг орон нутгаа төлөөлөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилан оролцсон нь ямар нэгэн баяр наадам, ойн арга хэмжээтэй хамааралгүй болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Э.АЗЗАЯА

Санал-4

Тайлбар

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх "Иргэний боловсрол" хөтөлбөр нь эрх зүйн соёл, ёс зүйтэй иргэнийг төлөвлүүлэх зорилготой бөгөөд зорилгодоо хүрэх арга замыг дараах 3 зорилтоор тодорхойлсон

1. Иргэний эрх зүйн боловсролын орон нутгийн тогтолцоог боловсронгуй болгох
2. Иргэний боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг бүрдүүлэх
3. Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааг оновчтой, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах

Иргэний боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг бүрдүүлэхдээ Хүний нөөцийн, Санхүүгийн, Материалын нөөц бүрдүүлэхээр зорилт тавьсан. Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд шаардагдах хүний нөөцийн хийгээд техник тоног төхөөрөмжийн нөөц боломж сумдад төдийгүй аймгийн хэмжээнд дутагдалтай байгаа. Хөтөлбөрийн хүрээнд эдгээр тулгамдаж асуудлыг шат дараатай шийдвэрлэх, үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор дараах хөрөнгийг үйл ажиллагаанд авч ашиглаж байгаа.

1	Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажилд ашиглах, тоног төхөөрөмжтэй болох	Аппрат - Canon EOS 7D mark II body камер /шинэ/	3000000	3000000
		Хувилагч - Canon iR 2530 хувилагчмашин /шинэ/	5200000	5200000
		notebook - dell /Шинэ/ - 1ш.	1300000	1300000
2	Цагдаагийн газрын дэргэд хууль сурталчлах танхим байгуулах	notebook - dell /Шинэ/ - 1ш	1800000	1800000
		Алсынзайнмикрофон 2ш х250000	500000	500000
		Проекторынсуурь /таазны/ - 1 ш	100000	100000
		Вэбкамер - 1 ш	150000	150000
		Хэвлэгч, хувилагч - 1 ш	200000	200000
		Сүлжээнийтөхөөрөмж 1ш	250000	250000
		Холбогчутаснууд	300000	300000
Дүн			12800000	12790000

Аппратыг сургалт, сурталчилгааны богино хэмжээний шторк бэлтгэх, бичлэг хийх, зохион байгуулж байгаа үйл ажиллагааны явцыг бэхжүүлэх зорилгоор ашиглаж байна.

Хувилагч машин нь хууль, тогтоомжийн сангийн өөрчлөлт хөдөлгөөн хийх, эрх зүйн сурталчилгааны хуудас, сургалтын материал, гарын авлага материалыг олшируулахад ашиглаж байна.

Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн НҮБ-ын санхүүжилтээр хэрэгжсэн Эрх зүйн туслалцааны төвийн төслийг хэрэгжүүлж, төслийн хугацаа дууссан ба хөрөнгийг Хууль зүйн туслалцааны төвд шилжүүлэхэд Хууль зүйн яам болон төслийн зохицуулагч нарт хүсэлт тавьж сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглах проектортой болсон. Үндсэндээ сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглах зөөврийн компьютергүй 6 жил үйл ажиллагаа зохион байгуулсан ба ЗДТГ-ын дарга, Хэлтсийн дарга нарын албан хэрэгцээний зөөврийн компьютер, зарим тохиолдолд суурин компьютер ашиглаж байсан ба хөтөлбөрийн хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүнтэй болгож, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд 2016 оны аймгийн Цагдаагийн газар "Эрх зүйн танхим"-тай болж, үйл ажиллагаанд ашиглах notebook, Алсынзайнмикрофон, Проекторынсуурь, Вэбкамер, Хэвлэгч, Сүлжээнийтөхөөрөмж, Холбогчутаснууд зэрэг хэрэгслийг хөтөлбөрөөс өгч, үйл ажиллагаа явуулах иргэдэд сургалт сурталчилгаа зохион байгуулах, хууль тогтоомжийг сурталчлах нөхцөл боломж бүрэн бүрдсэн.

Монгол улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т "Засгийнгазар, холбогдохтөрийнзахиргаанытөвбайгууллага, бүхшатныиргэдийнТөлөөлөгчдийнХурал, Засагдаргахуультогтоомжийгөөрийнбүрэнэрх, чигүүргийндагуухарьяалахсалбар, нутагдэвсгэрийнхэмжээндолоннийтэдтаниулахажлыгзохионбайгуулна", Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а"-д "хуультогтоомж, Засгийнгазар, Хурал, Засагдаргыншийдвэрийгсурталчлах, биелэлтийгньхангаажлыгнутагдэвсгэрийнхээхэмжээндзохионбайгуулах" үүрэг нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад бий.

Аймгийн Засаг дарга хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан болно.

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Энхзаяа

Холбогдогч байгууллагаас ирүүлсэн саналын хариу:

Санал -1: Тайланд тодорхой бичигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Санал-2: Хөл бөмбөгийн талбайг барих ажил нь сүүлийн 4 жил үргэлжилж байгаа тул бүрэн дуусгаж, ашиглалтад оруулах нь зүйтэй байна. Саналыг хүлээн авах боломжгүй байна.

Санал-3: Төсвийн тухай хуулийн 60.3.3-д ОНХС-ийн хөрөнгийг “үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, ойн арга хэмжээ, шашины зан үйлийн болон ёслолын зардал”-д зарцуулахыг хориглосон, Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2014 оны 147 дугаар тогтоолын 6-д “ улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.

Санал – 4: Тайланд тодорхой бичигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Хавсралт-3

Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт

№	Хариуцах эзэн	Акт, албан шаардлага, зөвлөмжийн зөрчлийн утга	Биелсэн эсэх	Тайлбар
1		Акт		
1.1	Засаг дарга	Ренчинлхүмбэ сумын 2015 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “Зүүн хорооны урд хэсгийн эрчим хүчний өргөтгөл” ажлын захиалагчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг суутган тооцоогүй	0	Биелээгүй
1.2	Засаг дарга	Цэцэрлэг сум Үндэсний баяр наадмын зардлыг тогтоосон хязгаараас хэтрүүлэн зарцуулсан	0	Биелээгүй
2		Албан шаардлага		
2.1	Засаг дарга	Галт сумын 2015 оны ОНХС-ийн хөрөнгөөр Нью Эрхэм ХХК-нийн гүйцэтгэсэн халуун усны барилгыг зураг төсвийн дагуу хийж ашиглалтад оруулах	0	2017 оны 4 сард аудитын баг ажиллахад мөн ашиглалт ороогүй байна.
2.2	Засаг дарга	Цагааннуур сумын 2014 оны ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн Халуун ус, иргэний танхимын барилга зураг төсвийн дагуу хийгдээгүйгээс ашиглалтад ороогүй	0	2016 оны 9 сард аудитын баг ажиллахад ашиглалт ороогүй байна.
3		Зөвлөмж		
3.1	Аймгийн ИТХ-ын дарга	Иргэдийн саналаар дэмжигдсэн, тэдний оролцоог хангасан төсөл арга хэмжээний төслийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж байх	86%	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлуудыг ИТХ-д оруулж батлуулж байна.
3.2		Төсвийн тухай хууль, сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т зааж, зөвшөөрсөн аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцүүлж баталж байх	89%	
3.3	Аймгийн Засаг дарга	Иргэдийн саналаар дэмжигдсэн, тэдний оролцоог хангасан хөтөлбөр, төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх	89%	
3.4		Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж болох чиг үүрэгт заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байх	89%	
3.5		Дотоод аудитын албаар ОНХС-ийн гүйцэтгэл, санхүүжилтийн байдалд хяналт хийлгэх	12.5%	
3.6	Сумын ИТХ-ын дарга	Иргэдийн саналаар дэмжигдсэн, тэдний оролцоог хангасан төсөл арга хэмжээний төслийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж байх	33%	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлуудыг ИТХ-д оруулж батлуулж байна.
3.7		Сумын ОНХС-аар хэрэгжүүлэх чиг үүрэгт заасан хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж байх	75%	Хөтөлбөр нэрийн дор баяр наадам тэмдэглэж, урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлсэн байна.
3.8		ОНХС -ийн төлөвлөлт гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт, үнэлгээ хийж, нийтэд ил тод мэдээлж байх	20%	5 сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо хяналт хийсэн байна.
3.9	Сумын Засаг дарга нарт	Иргэдийн саналаар дэмжигдсэн, тэдний оролцоог хангаж санал авсан, сумын ОНХС-ийн чиг үүрэгт нийцсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх	44%	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлуудыг ИТХ-д оруулж батлуулж, хэрэгжүүлсэн байна.
3.10		ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн байдалд хяналт тавьж гарсан зөрчлийг тухай бүр арилгуулж байх	33%	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн байдалд хяналт тавьж ажиллаагүй байна.
Нийт			60.9%	



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 5 сарын 1 өдөр

Дугаар А/11

Мөнгө

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 121, 2017 оны А/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Сумдын засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Төмөрбаатар, Засаг дарга Л.Ганболд, Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Азаяа, сумдын засаг дарга нарт зөвлөсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Г.Эрдэнэчимэг/, ахлах аудитор /Б.Тэгшдэлгэр/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ОЮУНГЭРЭЛ